

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Зөрчлийн бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Энэбиш Бямбацэцэг

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх							
1	Боловсролын салбарын болон хяналт шалгалтын холбогдох хууль, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох санал өгөх, хяналт шалгалтын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулж батлуулах	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо-2	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо-1	-ХҮҮХ-оос зохион байгуулсан уулзалтаар хөндөгдсөн асуудал буюу хяналт шалгалтын давхардлыг бууруулах, салбар хоорондын уялдааг хангах, нэгдсэн удирдамж батлах зэрэг агуулгын хүрээнд Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам” болон Засгийн газрын 2023 оны	3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					“Журам, загвар батлах тухай” 6 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам”-д өөрчлөлт оруулах ажилтай холбогдуулан аймаг, нийслэлийн ЭБАТ-уудад мэдээлэл хүргэж, чиглэл өгч ажилласан. -Засгийн газрын 2017 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардал тооцох журам”-ын 5.1-т “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны дараагийн жилийн зардлын төсвийг харьяа төрийн захиргааны төв байгууллагын санал, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн төсөв, шаардлагатай		
--	--	--	--	--	--	--	--

				тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголд оруулж шийдвэрлүүлнэ” гэж заасны дагуу Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардлыг тусгуулах саналыг хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардалтай хамтатган СХОГ-т хүргүүлсэн. - НПГ-аас зохион байгуулсан чиглэл тус бүрийн СХГ-ын төлөөлөлд "Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явц дахь прокурорын оролцоо" сэдвээр мэдээлэл өгөх, гарч буй үл ойлголцлыг нэг мөр болгох талаарх хэлэлцүүлэгт оролцож, санал өгсөн. -Боловсролын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах эрх бүхий албан тушаалтнуудад эрх олгох, цуцлах ажлыг хариуцан зохион байгуулж, тухай бүрт нь тушаалын төслийг боловсруулан, батлуулсан. Холбогдох журамд заасны дагуу үнэмлэх,		
--	--	--	--	--	--	--

					тэмдгийг албажуулан олгосон. Тайлант хугацаанд улсын /ахлах/ байцаагчийн эрх олгох 9, эрх цуцлах 6, нийт 15 албан хаагчийн материалыг хянаж, тушаалын төсөл боловсруулсан. Боловсролын сайдын баталсан А/01, А/51, А/114, А151, А/181, А/240, А/14, А/52, А/115 дугаарын тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнасан. Хавсралт: 2 файл		
2	Боловсролын салбарын хяналтын чиглэлээр нийслэл, орон нутагт их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 355 объектод төлөвлөгөөт шалгалт хийх ажлыг нэгдсэн бодлого, арга зүйгээр хангах	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Албан шаардлагын хэрэгжилтийн хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь-100% Албан шаардлагын хэрэгжилтийн хувь-70% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)-80%	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь-50% Албан шаардлагын хэрэгжилтийн хувь-60% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)-70%	-Боловсролын яам, Эрүүл мэндийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчдын хамтран баталсан "Боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" удирдамжид нэгдсэн дугаар олгож албажуулан аймаг, нийслэлийн Боловсролын газарт хүргүүлсэн. Хяналт шалгалтын ажил 11	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					дүгээр сарын 14 хүртэлх хугацаанд үргэлжилнэ. Тус төлөвлөгөөт хяналт шалгалттай холбогдуулан аймаг, нийслэлийн улсын /ахлах/ байцаагчдыг шаардлагатай мэдээлэл, удирдлагаар ханган ажиллаж байна. - Тайлант хугацаанд 82 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт /201/, 41 төлөвлөгөөт бус хяналт шалгалт /56/, 9 урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, 5 гүйцэтгэлийн хяналт шалгалт хийн 257 зөрчлийг илрүүлэн холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Улсын /ахлах/ байцаагчдын төлөвлөгөөт хяналт шалгалтын үеэр илрүүлсэн зөрчил, түүний шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Хавсралт: 2 файл		
3	Сүхбаатар,	Шалгалт хийсэн	-	Шалгалт хийсэн	-Хяналт үнэлгээний	4-р сар, 5-	Өөрийн

	Дундговь аймгийн боловсролын сургалтын байгууллагуудад нэгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	объектын гүйцэтгэлийн хувь Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)		объектын гүйцэтгэлийн хувь - 50% (1) Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь - 60% Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар) - 45%	үндэсний хорооны 2024 оны “Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай” 02 дугаар тогтоол, Боловсролын яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасны дагуу Сүхбаатар аймгийн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагууд болон холбогдох бусад газарт хяналт шалгалт хийх “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжид нэгдсэн дугаар олгов. Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан тус удирдамжийн хүрээнд эрх бүхий албан тушаалтанд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх явцад Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 2-р багт байрлах Мэргэжлийн боловсролын	р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар	үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	---	--	---	--	-----------------------------------	---

					сургуульд холбогдох БГ202502 бүртгэлийн дугаартай хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн материалыг хянаж, арга зүйгээр ханган ажилласан. Хавсралт: 2 файл		
4	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь	Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь-100	Ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь-100	Иргэнээс ирсэн гомдлын дагуу СУИС-ийн Дүрслэх урлагийн академийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамжийн төслийг боловсруулж, Салбарын улсын ерөнхий байцаагчийн 03-00/06 дугаартай удирдамжийг батлуулсан. Хяналт шалгалт хийх явцад тус сургуулийн хичээлийн 5 дугаар байрны барилга байгууламж нь эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй, багш, ажилтан, суралцагчийн амь нас, эрүүл мэндэд эрсдэл учирч болзошгүй нөхцөл байдал	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 80% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					илэрсэн тул Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам болон холбогдох бусад газарт албан тоот хүргүүлсэн. Мөн хяналт шалгалтад шаардлагатай мэдээллийг авах зорилгоор "Дотоод албан бичиг"-ийн төсөл боловсруулан холбогдох газарт хүргүүлсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг "Боловсролын яамны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавьсан хяналтын бүртгэл"-д бүртгэж, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Хавсралт: 1 файл		
1.2. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангах							
5	Салбарын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, хяналт тавих, мэдээллийн сан	Зөрчлийн хэргийн тоо Торгууль, шийтгэврийн барагдуулалтын хувь Мэдээллийн сангийн бүрдүүлэлт	Зөрчлийн хэргийн тоо - 116 Торгууль, шийтгэврийн барагдуулалтын хувь - 92% Мэдээллийн сангийн бүрдүүлэлт - 100%	Зөрчлийн хэргийн тоо - Тухай бүр Торгууль, шийтгэврийн барагдуулалтын хувь - 90% Мэдээллийн сангийн	-Тайлант хугацаанд 82 объектод төлөвлөгөөт шалгалт /201/, 41 төлөвлөгөөт бус хяналт шалгалт /56/, 9 урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, 5 гүйцэтгэлийн хяналт шалгалт хийснээс 257	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын

	бүрдүүлэх			бүрдүүлэлт - 100%	зөрчлийг илрүүлэн холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. Үүнээс 73 зөрчлийг хялбаршуулсан журмаар, 10 зөрчилд зөрчлийн хэрэг нээн шалган шийдвэрлэжээ. Мөн удирдах албан тушаалтны тогтоолоор харьяаллын дагуу шилжүүлсэн 4, татгалзаж шийдвэрлэсэн 10 зөрчил байна. Шийтгэлээс чөлөөлсөн 2, шүүхийн шийдвэрээр шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосон 1 тохиолдол байна. Нийт 29 сая 590 мянган төгрөгийн торгох шийтгэл оногдуулснаас 500 мянган төгрөгийн торгох шийтгэлийг шүүхийн шийдвэрээр хүчингүй болгосон ба торгох шийтгэлийн үлдэгдэлгүй. Дээрх нийт мөнгөн дүнд улсын орлого болгосон 1958.0, хөнгөрүүлсэн 400.0 мянган төгрөгийг	сар, 12-р сар	үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	-----------	--	--	-------------------	--	---------------	---

					оруулж тооцоогүй болно. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаар албадан гүйцэтгүүлсэн тохиолдолгүй. -Мөн зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авхуулах тухай эрх бүхий албан тушаалтны 343 заалт бүхий 66 албан даалгаврыг холбогдох иргэн, хуулийн этгээдэд хүргүүлсэн байна. -Сүхбаатар, Дорнод аймгийн БГ- ын боловсролын хяналтын улсын байцаагчдын БГ202501, БГ202502, БГ20250513/01 бүртгэлийн дугаартай хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн материалыг хянаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Түүнчлэн Сүхбаатар аймгийн Сум дундын анхан шатны шүүхээс боловсролын хяналтын улсын байцаагчийн ХЖ-аар зөрчил шалган шийдвэрлэж, 0855588 дугаартай шийтгэлийн		
--	--	--	--	--	--	--	--

					хуудсаар шийтгэл ногдуулсан шийдвэрт гомдол гаргасан иргэний нэхэмжлэлээр хэргийн материал татах, шүүх хуралд оролцуулах болсон тухайд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав. Асуудлыг магадлан шалгах ажил үргэлжилж байна. -ЗГ- ын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан "Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам"-ын дагуу Зөрчилд шийтгэл ногдуулах, Хялбаршуулсан журмаар шийдвэрлэх зөрчилд шийтгэл ногдуулах, Шийтгэлээс чөлөөлөх хуудасны хэрэглээнд хяналт тавин ажиллаж байна. Хавсралт: 3 файл		
6	Эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, ЭБАТ-ны өөрчлөлт болон	Мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан улсын байцаагчийн тоо Хүргүүлсэн судалгаа,	Мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан улсын байцаагчийн тоо-32 Хүргүүлсэн судалгаа,	Мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан улсын байцаагчийн тоо-Тухай бүр Хүргүүлсэн	-Салбарын хяналтын газарт эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт гарсантай холбогдуулан ЭБАТ-ны дэлгэрэнгүй	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	бусад мэдээллийг прокурорын байгууллагад хүргүүлэх	мэдээллийн тоо	мэдээллийн тоо -6	судалгаа, мэдээллийн тоо- Тухай бүр	мэдээллийг НПГ-т хүргүүлсэн. -УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2019.10.11- ний өдрийн “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төрийн үйл ажиллагаан дахь цахим шилжилтийг дэмжих, зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох зорилгоор “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг холбогдох байгууллагууд үе шаттайгаар зохион байгуулж байна. Тус ажлын хүрээнд УЕПГ- ын сургагч багш нартай хамтран Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж	сар, 10-р сар, 11-р сар	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	----------------	-------------------	---	---	-------------------------------	---

					байгаа буюу Боловсролын яам, Нийслэлийн боловсролын газрын боловсролын хяналтын улсын байцаагчдыг хамруулсан сургалтыг 05 дугаар сарын 23-нд зохион байгуулав. “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн хэрэглэгчдэд зориулсан сургалтад 25 /ТТХГ-4, нийт 29/ ЭБАТ хамрагдав. - НПГ-аас 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн Ц-1/583 дугаартай албан бичгээр ирүүлсэн Улсын ерөнхий прокурорын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд прокурор хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай А/48 дугаар тушаалыг хүлээн авч, эрх бүхий албан тушаалтнуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах чиглэл өгсөн. Мөн тус албан тоот болон тушаалыг аймаг, нийслэлийн эрх бүхий албан тушаалтнуудад		
--	--	--	--	--	---	--	--

					танилцуулсан тухай 11/1390 дугаартай албан бичгээр НПГ-т хариу хүргүүлсэн. Мөн тус газраас ирүүлсэн Ц-1/62 дугаартай албан бичгийн дагуу Эрх бүхий албан тушаалтнуудын судалгаа болон Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тоон мэдээллийг нэгтгэн гаргаж, имэйлээр хүргүүлсэн. УЕПГ-ын 1/7753 дугаартай албан тоотын дагуу аймгуудын БГ-ын эрх бүхий албан тушаалтнуудыг "Шүүх эрх мэдлийн байгууллагуудын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, чадавхийг сайжруулах" төслийн хүрээнд сургалтад хамруулах ажлыг зохион байгуулалтаар ханган ажиллав. НПГ-аас... Хавсралт: 10 файл		
7	Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авах, прокурорын нэгдсэн	Бүртгүүлсэн гомдол мэдээллийн тоо Торгууль	Бүртгүүлсэн гомдол мэдээллийн тоо-Тухай бүр Торгууль	Бүртгүүлсэн гомдол мэдээллийн тоо-Тухай бүр Торгууль	Тайлант хугацаанд салбарын хэмжээнд нийт 83 зөрчлийг прокурорын нэгдсэн	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

	бүртгэлд бүртгүүлэх, тайлагнах	шийтгэврийн барагдуулалтын хувь	шийтгэврийн барагдуулалтын хувь-100	шийтгэврийн барагдуулалтын хувь-85	бүртгэлд бүртгүүлснээс 73 зөрчлийг хялбаршуулсан журмаар, 10 зөрчилд зөрчлийн хэрэг нээн шалган шийдвэрлэв. Мөн удирдах албан тушаалтны тогтоолоор харьяаллын дагуу шилжүүлсэн 4, татгалзаж шийдвэрлэсэн 10 зөрчил байна. Шийтгэлээс чөлөөлсөн 2, шүүхийн шийдвэрээр шийтгэлийн хуудсыг хүчингүй болгосон 1 тохиолдол байна. - Эрх бүхий албан тушаалтнуудын БЯ- 20250403/02, БЯ- 20241206/07, БЯ- 20241209/08, БЯ- 20241211/09 дугаартай материалууд болон 2502000221 дугаартай зөрчлийн хэргүүдийг Нийслэлийн прокурорын газрын № Ц-3/1443 тоот албан бичгийн дагуу татан авч, архивын нэгж үүсгэн, мэдээллийн санд авав. -"....." их сургуулийн захиргаа	сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--------------------------------------	---------------------------------------	---	--	---	---	---

					багш, ажилчдаасаа санал авахгүйгээр албан тулгалт хийн цалингаас 200,000 төгрөг суутгаж авах шийдвэр гаргасан гэх гомдлыг “Боловсролын яамны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавих хяналтын бүртгэл”-д бүртгэж, БЯ20250403/02 бүртгэлийн дугаартай гомдол мэдээллийг Прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Тус гомдлыг Удирдах албан тушаалтны тогтоолоор харьяаллын дагуу шилжүүлсэн. - Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 03-00/06 дугаартай удирдамжийн хүрээнд СУИС-ийн Дүрслэх урлагийн академийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх явцдаа улсын байцаагчийн илрүүлсэн сургалтын байгууллагад		
--	--	--	--	--	---	--	--

					тавигдах шаардлагыг зөрчсөн гэх зөрчлийг Боловсролын яамны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавих хяналтын бүртгэлд бүртгэж, БЯ20250326/01 дугаартай мэдээллийг прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Хавсралт: 2 файл		
--	--	--	--	--	--	--	--

3.1. Төрийн захиргааны төв байгууллагын болон харьяа байгууллагын хүний нөөцийн удирдлагын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.

8	Хяналт шалгалт хэрэгжүүлэх доод шатны нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сургалт зохион байгуулах	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо Зохион байгуулсан сургалтын тоо Хамрагдсан улсын байцаагч	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо-20 Зохион байгуулсан сургалтын тоо-1 Хамрагдсан улсын байцаагч-60	Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо-10 Зохион байгуулсан сургалтын тоо-1 Хамрагдсан улсын байцаагч-30	-УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2019 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төрийн үйл ажиллагаан дахь цахим шилжилтийг дэмжих, зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
---	--	---	---	---	---	---	--

					ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох зорилгоор “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг холбогдох байгууллагууд үе шаттайгаар зохион байгуулж байна. Тус ажлын хүрээнд УЕПГ- ын сургагч багш нартай хамтран Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа буюу Боловсролын яам, Нийслэлийн боловсролын газрын боловсролын хяналтын улсын байцаагчдыг хамруулсан сургалтыг 05 дугаар сарын 23-нд зохион байгуулав. “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-ийн хэрэглэгчдэд зориулсан сургалтад Боловсролын яамны Салбарын хяналтын газар, Нийслэлийн боловсролын газрын Салбарын хяналтын хэлтсийн болон Төрийн тусгай		
--	--	--	--	--	--	--	--

					хамгаалалтын газрын 29 ЭБАТ хамрагдав. Хавсралт: 9 файл		
9	Боловсролын хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах ажлыг хариуцан зохион байгуулж, үнэмлэх, тэмдгийн хэрэглээнд хяналт тавих	Эрх олгосон, цуцалсан улсын байцаагчийн тоо Хяналт тавьсан үзүүлэлт (хувиар)	Эрх олгосон, цуцалсан улсын байцаагчийн тоо - 15 Хяналт тавьсан үзүүлэлт (хувиар) - 100%	Эрх олгосон, цуцалсан улсын байцаагчийн тоо - Тухай бүр Хяналт тавьсан үзүүлэлт (хувиар) - 100%	-Боловсролын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах эрх бүхий албан тушаалтнуудад эрх олгох, цуцлах ажлыг хариуцан зохион байгуулж, тухай бүрт нь тушаалын төслийг боловсруулан, батлуулсан. Холбогдох журамд заасны дагуу үнэмлэх, тэмдгийг үйлдүүлэн албажуулж, бүртгэлд хамруулан олгосон. Тайлант хугацаанд улсын /ахлах/ байцаагчийн эрх олгох 9, эрх цуцлах 6, нийт 15 албан хаагчийн материалыг хянаж, тушаалын төсөл боловсруулсан. Боловсролын сайдын баталсан А/01, А/51, А/114, А/151, А/181, А/240, А/14, А/52, А/115 дугаарын тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнасан. -Засгийн газрын 2023 оны 6	1-р сар, 2- р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам”-ын 1.12-т заасны дагуу хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдгийн дардсын судалгааг улирал тутамд авч, хяналт тавин ажиллаж байна. Хавсралт: 2 файл		
10	Улсын байцаагчийн үйлдэх хяналт шалгалтын баримт бичгийн хэрэглээнд хяналт тавих, нэгдсэн дугаар олгож бүртгэлжүүлэх	Хэвлэмэл хуудасны тоо Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо Хяналт тавьсан үзүүлэлт /хувиар/	Хэвлэмэл хуудасны тоо-376 Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо-68 Хяналт тавьсан үзүүлэлт /хувиар/-100	Олгосон хэвлэмэл хуудасны тоо - Тухай бүр Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо - Тухай бүр Хяналт тавьсан үзүүлэлт /хувиар/-100	Тайлант хугацаанд СХГ-ын улсын ахлах байцаагч нарт хяналт шалгалтын удирдамжийн хэвлэмэл хуудас-40, зөвлөмжийн хэвлэмэл хуудас-2, хяналт шалгалтын тэмдэглэлийн хэвлэмэл хуудас-21, улсын ахлах байцаагчийн албан шаардлагын хэвлэмэл хуудас-48, нийт 119 ширхэг хэвлэмэл хуудас олгосон. Мөн хяналт шалгалтын удирдамж 19, улсын ахлах байцаагчийн албан шаардлага 7 буюу нийт хяналт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 85% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					шалгалтын 26 баримт бичигт нэгдсэн дугаар олгож, БШУС-ын 2023 оны А/118 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хяналт шалгалтын баримт бичгийг бүртгэх, нэгдсэн дугаар олгох, хянах, хадгалах журам”-д заасны дагуу бүртгэл хөтөлсөн. -Монгол улсын Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан "Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам"-ын дагуу эрх бүхий албан тушаалтанд шийтгэлийн хуудас олгож, бүртгэлд хамруулсан. Хавсралт: 3 файл		
11	Салбарын хяналтын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана	Мэдээллийн тоо	2024 оны гүйцэтгэлийн түвшингээр	Хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна.	-Хяналт, үнэлгээний үндэсний хороо, Улсын ерөнхий прокурор, Нийслэлийн прокурорын газар болон холбогдох бусад байгууллагаас ирсэн хяналт шалгалт, хяналт шалгалтыг гүйцэтгэх эрх бүхий албан	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн

					тушаалтнуудтай холбоотой мэдээ мэдээлэл, тогтоол шийдвэр, албан бичгийг тухай бүрт нь улсын /ахлах/ байцаагч нарт биечлэн болон цахим байдлаар танилцуулан, удирдлага арга зүйгээр ханган ажилласан. -Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 9/2844 дугаар албан бичгээр ирүүлсэн тус яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн хамтран баталсан “Хоол хүнсээр дамжих өвчнөөс урьдчилан сэргийлэх” тухай зөвлөмжийг аймгуудын боловсролын газарт хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах чиглэл өгсөн. -СУИС-ийн Дүрслэх урлагийн академийн зарим үйл ажиллагаанд хийсэн	хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	---

					төлөвлөгөөт бус хяналт шалгалтын дүнг удирдлага болон шалгуулагч этгээдэд танилцуулж ажилласан. Хавсралт: 3 файл		
3.2. Урт болон богино хугацааны бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн болон үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналт, архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.							
12	Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь мэдүүлэх	Хуульд заасан хугацаанд мэдүүлсэн байна.	Хөрөнгө орлогын мэдүүлэг-1	Хөрөнгө орлогын мэдүүлэг-1	Төрийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлсэн.	1-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
13	Төрийн албан хаагчийн чиг үүргийн хүрээнд хариуцаж шийдвэрлэсэн баримт бичгийг зохих хууль, журмын дагуу архивын баримт үүсгэн ТЗУГ-т хүлээлгэн өгөх	Архивын баримтыг хүлээлгэн өгсөн байна.	Хүлээлгэн өгсөн архивын баримт - 2	Хүлээлгэн өгсөн архивын баримт - 2	-Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд байрлах Сингапур сүүл оф Монголиа сургуульд холбогдох 2302000214 дугаартай Зөрчлийн хэрэг, Ерөнхий боловсролын Гэрэлт ирээдүй сургуульд холбогдох 03-00-07/01 дугаартай	1-р сар, 2-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ

					хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн материал, Ерөнхий боловсролын Шилдэг сургуульд холбогдох 03-00-07/02 дугаартай хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн материал, Нийслэлийн Ерөнхий боловсролын 6 дугаар сургуульд холбогдох 03-00-22/02 дугаартай хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн материал, “Монголын бүжгийн спортын нэгдсэн холбоо” НҮТББ-д холбогдох 2302000199 дугаартай Зөрчлийн хэрэг зэрэг нийт 5 боть хадгаламжийн нэгжийг архивын ажилтанд хүлээлгэн өгсөн.		төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
14	Төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг тайлагнах	Боловсруулж, батлуулсан төлөвлөгөө Гүйцэтгэлийн тайлан	Боловсруулж, батлуулсан төлөвлөгөө-1 Гүйцэтгэлийн тайлан-2	Боловсруулж, батлуулсан төлөвлөгөө-1 Гүйцэтгэлийн тайлан-1 /6/	Төрийн албан хаагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн тайланг хугацаанд нь	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ

					тайлагнасан.	сар	төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
15	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, хариу хүргүүлэх	Албан бичиг, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Шийдвэрлэлтийн хувь - 100%	Шийдвэрлэлтийн хувь - 100%	Оны эхний 5 сарын байдлаар албан бичиг 18, өргөдөл гомдол 50, нийт 68 албан бичиг, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
16	Цаг үеийн нөхцөл шаардлага болон дээд шатны байгууллага, удирдлагаас өгсөн хууль ёсны шийдвэрийн дагуу ажил үйлчилгээг гүйцэтгэх	Цаг хугацаанд нь хийж хэрэгжүүлсэн байна.	Хэрэгжүүлсэн арга хэмжээ - Тухай бүр Гүйцэтгэлийн хувь - 100%	Хэрэгжүүлсэн арга хэмжээ - Тухай бүр Гүйцэтгэлийн хувь - 100%	-Боловсролын сайдын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/216 дугаар тушаалаар Ерөнхий боловсролын зарим сургуулийн удирдлагын систем, суралцахуйн удирдлагын системийн суурилуулалт, нэвтрүүлэлт, ашиглалт, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх зорилго	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					бүхий ажлын хэсгээс нийлүүлэгч компаниудын удирдлага болон төлөөлөлд хяналт шалгалтын дүнг танилцуулах уулзалтад оролцож, чиг үүргийн дагуу мэдээлэл өгсөн. - Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн "Эд хөрөнгийн тооллого хийх тухай" А/132 дугаар тушаалаар байгуулсан тооллогын комисст орж ажилласан. - Нийслэлийн прокурорын газраас зохион байгуулсан чиглэл тус бүрийн Салбарын хяналтын газрын төлөөлөлд "Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явц дахь прокурорын оролцоо" сэдвээр мэдээлэл өгөх, гарч буй үл ойлголцлыг нэг мөр болгох талаар санал солилцох, хамтран ажиллах тухай хэлэлцүүлэгт оролцон холбогдох мэдээллийг авч, санал өгсөн. -		
--	--	--	--	--	---	--	--

1	Хууль эрх зүйн мэдлэг, чадвараа нэмэгдүүлэх	Шинээр болон шинэчлэн баталсан хууль, эрх зүйн баримт бичгүүдийг тухай бүр уншиж судлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. Чадвараа нэмэгдүүлнэ.	Хууль эрх зүйн мэдлэг, чадвар нэмэгдсэн байна.	Хууль эрх зүйн мэдлэг, чадвар нэмэгдсэн байна.	Салбарын хууль тогтоомж болон Зөрчлийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг уншиж, судалж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%
2	Танхимын болон цахим сургалтад хамрагдан мэдлэг, боловсролоо нэмэгдүүлнэ.	Яам болон холбогдох бусад газраас зохион байгуулсан цахим болон танхимын сургалтад хамрагдана.	Мэдлэг мэдээлэл, ур чадвар нэмэгдсэн байна.	Мэдлэг мэдээлэл, ур чадвар нэмэгдсэн байна.	-Боловсролын дэлхийн түншлэл Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл"-ийн хүрээнд Боловсролын яам, харьяа байгууллагын албан хаагч нарт зориулсан "Монгол дохионы хэлний харилцааны анхан шат"-ны мэдлэг олгох 30 цаг буюу 5 өдрийн танхимын сургалтад хамрагдсан. Сургалтын үр дүнг тодорхойлох шалгалтыг амжилттай өгч, батламж гардсан. -Байгууллагын "Мэдээллийн цаг" арга хэмжээнд тогтмол хамрагдан мэдээлэл авч байна. Тухайлбал, Юнайтед менежмент консалтинг ХХК, БХЯ-тай хамтран зохион байгуулсан "Ажлын байрны ёс зүй", "Эх оронч Монгол, Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх", ОБЕГ, ЭЗХЯ-аас хийсэн "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлаа хангах арга хэмжээ", "Хиймэл оюун"	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95%

					сэдвээр болон "Хувь хүн, байгууллагын кибер аюулгүй байдал, кибер гэмт хэргийн хуулийн хариуцлага", "Хөрөнгө оруулалт ба хөрөнгийн зах зээлийн тухай" сэдвээр мэдээлэл авсан. Хавсралт: 1 файл		
3	Монгол бичгийн мэдлэг, чадвараа нэмэгдүүлэх.	Монгол бичгийн дүрмийн мэдлэгээ нэмэгдүүлэх, унших чадвараа бататгах.	-	Монгол бичгийн мэдлэг, чадвар нэмэгдсэн байна.	-Төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөхтэй холбоотойгоор Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн "Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай" 165 дугаар тогтоолын хүрээнд байгууллагаас зохион байгуулсан сургалтын өмнөх түвшин тогтоох сорилд хамрагдсан. -Бие даан бичмэл эх уншиж, мэдлэгээ нэмэгдүүлж байна.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 90%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Зөрчлийн бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, Энэбиш Бямбацэцэг /...../

Огноо: